



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 04/00-04001-02

Улаанбаатар хот

Уул уурхай, олборлолт болон хүнд
үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөрийн аюулгүй
байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах тухай

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд нийт 1748 үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдсэний 21.4 хувь буюу 374 нь уул уурхай, олборлолтын салбарт, 9,4 хувь буюу 164 нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт бүртгэгдсэн нь бусад эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаас хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Мөн 2023 онд үйлдвэрлэлийн осол хурц хордлогод нийт 408 хүн өртсөний 103 нь уул уурхай, олборлолтын салбарт бүртгэгдсэн байна. Дээрх ослын дүн мэдээнээс харахад уул уурхай, олборлолтын салбарт болон хүнд үйлдвэрт ажиллагсдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ажил олгогч бүр анхаарч ажиллах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Иймд гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, ажил хөдөлмөр эрхэлж буй хүн бүрийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор уул уурхай, олборлолтын салбарын болон хүнд үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч нарт дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллахыг ДААЛГАЖ байна.

1. Ашигт малтмалын ордыг ашиглах болон хүнд үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн асуудал, эрсдэлийн менежментийн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах;

2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээрээр тохиролцсон хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, хөдөлмөр зохион байгуулалт, цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах;

3. Ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;

4. Аж ахуйн нэгж, байгууллага бүр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийг байгуулан, ажилтны тооноос хамаарахгүйгээр нэг ба түүнээс дээш орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан ажиллуулах;

5. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг ханган ажиллах төлөвлөгөөг боловсруулан баталж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө, зардлыг төсөвлөн, зарцуулалтад хяналт тавих;

6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан, нийт ажилтнуудыг сургалтад бүрэн хамруулж, шалгалт өгсөн, зааварчилгаа авсан ажилтнуудыг ажлын байранд ажиллуулах;

7. Ажлын байрны нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтан бүрд олгох, зохистой хэрэглээнд хяналт тавих;

8. Хууль тогтоомжид заасан хэм хэмжээгээр ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулж, хураамжийг ажил олгогч бүрэн хариуцах;

9. Ажилтныг байнга оршин суугаа газраас нь өөр, алслагдсан газар байрлуулж ажил үүрэг гүйцэтгүүлж буй ажил олгогч нар нь уртын ээлж эхлэх болон дуусахад хөдөлмөрийн дотоод журмаар тогтоосон байршил бүхий газраас ажилтныг ажлын байранд хүргэх, буцаахдаа баталгаат тээврийн хэрэгслээр зорчих зохицуулалтыг хэрэгжүүлэх;

10. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу нийт ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах ажлыг тогтмол зохион байгуулж хэвших;

11. Ахуйн байрыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тохижуулах, эрүүл, шим тэжээлтэй хоол хүнс, ундны усаар хангах, өдөр тутмын үйл явцад хяналт тавих;

12. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт шаардлагын дагуу үйлдвэрлэлийн орчинд ашиглагдаж буй машин механизм, тоног төхөөрөмж, даралтат сав, химийн хорт болон аюултай бодисын аюулгүй байдлыг хангуулан, аюулгүй ажиллагааны заавар, дохио, санамж тэмдэгүүдийг байршуулан, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах;

13. Ажлын байранд үүсч болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилган, осол, хордлогын улмаас гэмтсэн, нас барсан ажилтны осол, гэмтэлд өртсөн шалтгаан, хүчин зүйлийг Засгийн газраас баталсан дүрмийн дагуу судлан тогтоож, холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллах;

14. Нийт ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжид нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад болзошгүй осол, гэмтлээс урьдчилан сэргийлж ажиллах;

15. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх;

Энэхүү албан даалгаврыг аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч бүр хэрэгжүүлэн, биелэлтийг үйл ажиллагаа эрхэлж буй нутаг дэвсгэрт хамаарах аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэн, орон нутгийн зөвлөл нь албан даалгаврын биелэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцэн, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж, шийдвэр гаргаж ажиллахыг даалгаж байна.

САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ



Б.НАРАНГАРАВ